

ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

/Сургуулийн номын санчаас 8-9 дүгээр ангийн сурагчдад зориулсан сургалтын модуль /

Д.Долгорсүрэн

/Нийслэлийн ерөнхий боловсролын 4-р сургуулийн сургалтын менежер/

Модулийн зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн ажилтанд БШУ-ны сайдын 2008 оны 10 сарын 21-ны Д/30 тоот “Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм”-д заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дунд ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга аргачлал эзэмшүүлэхэд оршино.

Модуль хэрэгжүүлэх зөвлөмж: ЕБС-ийн номын сангийн ажилтан та энэхүү модулийг хэрэгжүүлэхдээ дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.Үүнд:

- АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан 8-9-р ангийн сурагчийн дасгал ажлын ном, багшийн гарын авлага, сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж тус бүртэй нарийвчлан танилцаж судалсан байх
- Өөрийн албан тушаалын үлгэрчилсэн дүрмийн зорилго болох “Сургалтын агуулгад нийцэхүйц ном, хэвлэл болон баримт бичгийг цуглуулах эмхлэн төрөлжүүлэх хадгалах, ном хэвлэл, мэдээллээр багш, суралцагчдад үйлчлэх боловсролын түшиц байгууллага болно” гэж заасныг үндэслэн сургуулийн хэмжээнд дунд ангийн сурагчдад хичээлээс гадуур зохион байгуулж буй ажлын үр дүнг сурагчдын сонирхол сонголтонд тулгуурлан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгод нийцүүлэн ажлаа төлөвлөх
- Албан тушаалын үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын ажлын хүрээнд:
 - АМЧБО үйл ажиллагааны хэвлэмэл болон хэвлэмэл бус ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр багш, суралцагчдад түргэн шуурхай үйлчлэх, гарын авлагын фондыг үүсгэсэн байх
 - Номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, дунд ангийн сурагчид өөрийн сонирхолоо илэрхийлэх, өөрийгөө нээж илрүүлэх үйл ажиллагаанд туслах
 - Номын сангийн сан хөмрөгийг шинэчлэх хадгалах, хамгаалалтыг сайжруулах явцад сурагчдыг сонирхолын дагуу оролцоход дэмжлэг үзүүлэх
 - Номын сан үсэг дараалал болон төрөл ангийн каталоги сэдэвчилсэн картын зохион байгуулахад сурагчдын оролцоог нэмэгдүүлж танин мэдэхүйг хөгжүүлэх
 - Дунд анги удирдсан багш нартай хамтран сурагчдаас сонирхол, сонголтын судалгаа авах
 - Сурагчдын сонирхолын судалгаанд үндэслэн хичээл сонголт хийхэд сурагчдад зөвлөн туслах ном, хэвлэмэл материалаар хангах
 - Сурагчдад сонирхолын чиглэлээр мэргэжлийн ганцаарчилсан зөвлөгөөг мэргэжлийн дагуу өгөх

- АУБ нарыг ажил мэргэжлийг сонгох арга зүйн ном хэвлэлээр ханган, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд тус нэмэр болох

Албан тушаалын эрхийн дагуу “Хүүхдийн хөгжил, төлөвшилт, сонирхол хэрэгцээнд тулгуурлан хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, арга зүйн удирдлагаар хангах” ажлын хүрээнд:

- Хүүхдийн номын ордон болон хүүхэд залуучуудын мэдээллийн төвүүдтэй хамтран ажиллах сурагчдад танилцуулах
- Сурагчдын хэрэгцээ сонирхолд үндэслэн ном солилцооны арга хэмжээг зохион байгуулж дунд ангийн сурагчдын сонирхолыг татахуйц сургалт үйл ажиллагаа зохион байгуулах
- Сурагчдын дунд мэргэжлийн багш нартай хамтран сонирхол нь ажил мэргэжилд хэрхэн нөлөөлөх талаар эссэ, уралдаан зохион байгуулж, илтгэл судалгааны ажил өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Сурагчдын сонирхол болон сонголт хийх чадварын тухай сургууль дээр тусгайлсан мэдээллийн самбар болон ажил мэргэжлийн чиг баримжааны булан байгуулах

СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Дараах хүснэгтэд сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн бүрэлдэхүүний загварыг харууллаа.

Хөтөлбөрийн бүрэлдэхүүн	Агуулга
Үндэслэл	Сургуулийн номын санч нь сургалтын агуулгад нийцэхүйц ном, хэвлэл, бичиг баримт цуглуулах нь суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг чиглүүлэхэд тусалдаг.
Зорилтот бүлэг	Сургуулийн номын санчдад зориулав.
Зорилго	Суралцагчдын сэдэл тэмүүллийг нэмэгдүүлэх, анги дэвших болон сургууль төгссөн дараа амжилттай их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалт эсвэл хөдөлмөр эрхлэлтэд суралцагчдыг бэлтгэхэд зөвлөн туслах
Зорилт	Суралцагчдын ажил мэргэжлийн чиг баримжаа олох үйл явцад ном, хэвлэл мэдээллэл цуглуулах номын төрөл каталогыг ашиглаж сургахад дэмжлэг үзүүлэх
Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Сургуулийн орчинд номын сангийн үйл ажиллагааг сурталчилан таниулах, номын санчын нэг өдөр, номын каталог үүсгэх, ашиглах талаар хамтран ажиллах
Нөөц	Сургуулийн захирал, багш, суралцагчид, нийгмийн ажилтан, номын сан, ном гарын авлага, интернет холболт
Үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусах хугацаа	Сургалтын байгууллагын элсэлтийн хугацаа болон хичээлийн жилийн амралтыг харгалзан үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхойлсон байна.
Үнэлгээ	Хичээлийн жилийн төгсгөлд суралцагчдаас асуулга судалгаа авч болно.

Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн загвар:

Сургуулийн номын сангийн ажилтан та өөрийн сургуулийн алсын хараа, эрхэм зорилго болон тухайн хичээлийн жилийн зорилго, зорилтод нийцүүлэн өөрийн ажлыг төлөвлөн гаргаж байгаа. Энэ ажлын төлөвлөгөөндөө дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж буй танхимын болон танхимын бус үйл ажиллагааг тодорхой тусгаж, үр дүн нь сурагчдад гарах ахиц амжилтаар тооцогдох шаардлагатай. Иймд дунд ангийн сурагчдын дунд өөрийгөө таньж мэдэх, өөрийгөө нээх, сонголт хийх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сургууль дээр 8-9 дугаар ангийн сурагчдын дунд нэгдсэн байдлаар зохион байгуулах тухайлсан ажлын хөтөлбөрийн загварыг дараах хүснэгтээр үзүүлээ.

“Ажлын байран дээрх сургалт үйл ажиллагаа” зохион байгуулах хөтөлбөр /загвар/

Хөтөлбөрийн зорилго: сургуулийн дунд ангийн сурагчдаас авсан сонирхолын судалгаанд үндэслэн сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцуулан мэдлэг мэдээлэлтэй болно.

Зорилтот бүлэг:сургуулийн 8-9 ангийн 20 сурагч

Зохион байгуулагч: сургуулийн номын санч, 8-9 ангийн анги удирдсан багш нар

Хугацаа: Танхимын бус сургалт: 2021 оны 09 сарын 28 14-16.30 цаг

Танхимын сургалт: 2021 оны 09 сарын 30

Хүлээгдэж буй үр дүн: Сурагчид өөрийн сонгосон мэргэжлийн ажлын байртай танилцаж, “Номын санчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил сонголтод нөлөөлөх хүчин зүйлст үнэлгээ дүгнэлт хийсэн байна.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын нөөц	чиглүүлэгч
1	Сургуулийн номын санчтай уулзах	14.00-14.20	Номын сангийн өрөө	
2	Номын сангийн каталогтай хийх арга зүйтэй танилцах	14.20-15.00	Номын сангийн өрөө	
3	Сургуулийн номын сангийн фондын үйл ажиллагааг харах	15.00-15.50	8-9 ангийн 20 сурагч	
4	Номын сангийн ном зүйг ажиглах	15.50-16.20	8-9 ангийн 20 сурагч	
5	Номын сангийн мэдээллийн технологийн хөгжилтэй танилцах	16.20-16.30	8-9 ангийн 20 сурагч	
6	Сурагчид өөрсдийн сэтгэгдэл бичих	9 сарын 29	Сурагч бүрийн эссэ	
7	Бичсэн сэтгэгдлээ хуваалцах уулзалт зохион байгуулах	9 сарын 30	Сургуулийн хурлын танхим	
8	Үйл ажиллагааны дүгнэлт, үнэлгээ	9 сарын 30	Сургуулийн хурлын танхим	

Хөтөлбөр боловсруулсан /...сургуулийн номын санч /

Хөтөлбөртэй танилцсан:/ ангийн багш /

...../ ангийн багш /

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлээр дунд ангийн сурагчдын эзэмшсэн мэдлэг чадварт дэмжлэг үзүүлэх: Сургуулийн номын санч та ажил мэргэжлийн чиг

баримжаа олгох дунд ангийн суралцагчийн гарын авлагаар сурагчид ямар мэдлэг, чадвар эзэмшиж байгааг судлан танхимын болон танхимын бус аргаар анги удирдсан багш, эцэг эх, сургуулийн удирдлагуудтай хамтран сурагчдад хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар энэ хэсэгт дурдах болно.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдлэг, чадвар, холбогдох үйл ажиллагаа

Мэдлэг, чадвар	8-р анги	9-р анги	Номын санчын дэмжлэг
Өөрийгөө ойлгох	Суралцагчид өөрийн нас, хөгжилд тохирсон сонирхлоо тодорхойлох, түүний дагуу ажил мэргэжлийг яаж судлах, яагаад судлах хэрэгтэй талаар мэдэх	Суралцагчид өөрсдийн сонирхол, чадвар, үнэт зүйлийн онцлог болон сонирхож байгаа ажил мэргэжлийг багтаасан профайлтай болох	Сургуулийн нөөц боломжид тулгуурлан “Ажил мэргэжлийн чиг баримжааны булан” буюу “Ажил мэргэжлийн мэдээллийн эх сурвалжийн төв” ажиллуулах
Ажлын ертөнцийг ойлгох	Суралцагчдад өөрсдийн сайн мэддэг орчинд байдаг (тухайлбал сургуулийн орчин) ажил хөдөлмөрийн төрлүүдийг тодорхойлох, энэ ажил хөдөлмөрийг амжилттай эрхлэх эсвэл байгууллагыг амжилттай удирдаж ажиллуулахад ямар үүрэг хариуцлагууд байж болох талаар ойлголт өгөх	Суралцагчид тодорхой нэг бүтээгдэхүүнтэй холбоотой ажил хөдөлмөрийн төрлүүдийг мэдэх	Ажил мэргэжил хөдөлмөрийн зах зээл ажил мэргэжлийн төлөвт хийж ажлын ярилцлагатай холбоотой ур чадварын талаарх эрдэм шинжилгээний өгүүллэг ном гарын авлагын жагсаалт гаргах
Нөлөөллийг ойлгох	Суралцагчдад ажил мэргэжилтэй холбоотой элдэв цуу яриа чухал мэдээллийг үгүйсгэх сөрөг үр дагавартай тул худал, үнэнийг нь эх сурвалж материалыг судалж тогтоох хэрэгтэй гэдгийг ойлгуулах	Суралцагчид ажил мэргэжлийн сонголт хийхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн мэдээлэл хэрхэн нөлөөлдөгийг ойлгох	Сургуулийн номын санч, сургуулийн удирлага, интернетийн үйлчилгээ үзүүлдэг ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой эх сурвалж материал цуглуулах, сургуулийн номын санд байршуулах. Сургуулийн номын санч интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ямар мэдээлэл хаанаас олгох татах тухай саналыг хэлэх.
Ажил мэргэжлийн зорилго	Суралцагчдад өөрсдийн өнгөрсөн болон ирээдүйн ажил, амьдралын талаар урт хугацааны мөчлөгт хуваарь хэрхэн хийх талаар ойлголт өгөх	Суралцагчид ажил мэргэжлийн богино, дунд болон урт хугацааны зорилгоо тодорхойлно.	Номын сан нь сургалтын агуулгад нийцэхүйц ном, хэвлэл болон баримт бичиг цуглуулах, эмхлэн төрөлжүүлэх хадгалах, ном хэвлэл, мэдээллээр багш суралцагчдад

			үйлчлэх боловсролын байгууллага
Сонголт хийх / Шийдвэр гаргах	Суралцагчдад өдөр тутамд хийдэг үйл ажиллагааны зарим нь суралцагчдын өөрсдийн сонголт байдаг, энэ сонголт нь хүн бүрт өөр өөр байдаг талаар ойлголт өгөх.	Суралцагчид сонголт хийх шахалтад ороход ямар нөхцөл байдалтай тулгарч болохыг ойлгох	Сургуулийн ажил мэргэжлийн мэдээллийн төвөөс гадна сургуулийн вэб сайтад ажил мэргэжлийн чиг баримжааны материал холбогдох байгууллага мэдээллийн линкийг оруулж өгсөн байна.
Үйл хэрэг болгон хэрэгжүүлэх	Суралцагчид ахлах ангийн суралцагчдаас ажил мэргэжилтэй холбоотой ярилцлага хийхэд бэлтгэх болон ярилцлага авах	Сайн анкет бичихэд юу хэрэгтэй талаар ойлголттой болох	Сургуулийн түвшний ажил мэргэжлийн чиг баримжааны хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх ном зүйн талаар сургуулийн олон нийтэд хандсан мэдээлэлд оруулах хэрэгтэй.
Эргэн харах, дүгнэх	Суралцагчдад өөрийгөө ойлгоход дэмжлэг үзүүлэх үүднээс өмнөх ангиудад судалсан хичээлийнхээ талаар эргэн харж, дүгнэхэд туслах	Суралцагчдад өөрийгөө ойлгоход нь туслахын тулд өнгөрсөн хичээлийн жилүүдэд яаж сурсанаа эргэцүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Сургуулийн номын санг ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход хэрхэн ашиглаж болох талаар ярилцаж зөвлөмж хүргүүлэх

Модуль хэрэгжүүлэх арга зүй: Сургуулийн номын санч дунд ангийн сурагчид ажил мэргэжлийн талаар ямар мэдлэг ойлголттой болох агуулга эзэмшүүлэхэд хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар тодорхой мэдээлэлтэй боллоо. Харин энэ хэсэгт дээрх дэмжлэг болох ажлаа ямар арга зүйгээр зохион байгуулах боломжтой талаар мэдээлэл хүргэх гэж байна. Энэ нь 8-9 анги тус бүрдээ тухайн насны хүүхдийн зорилго, насны онцлогоос хамааран зохион байгуулж буй ажил нь ялгаатай байх боломжтой. Иймд анги тус бүр дээр ямар арга зүй хэрэглэх талаар дараах хүснэгтэд загвар гарган хүргэж байна.

8 дугаар анги	9 дүгээр анги
<ul style="list-style-type: none"> ▪ Каталог ашиглах арга ▪ Мэдээлэл цуглуулах арга ▪ Үг дамжуулах арга ▪ Амьдралын мөчлөгийн хуваарь ▪ Өдрийн тэмдэглэл хөтлөх ▪ Аккурамын арга ▪ Дүрд тоглох арга ▪ Төсөөлөх арга 	<ul style="list-style-type: none"> ▪ Багаар ажиллах ▪ Профайл ▪ Бүтээгдэхүүн ▪ Үзэл баримтлалаа илэрхийлэх арга ▪ Анкетын арга ▪ Хэвлэл мэдээллийг ашиглах ▪ Уншигчдын семинар хийх

/8-р анги /

Бүрэлдэхүүн: Өөрийгөө таньж мэдэх, ойлгох	Бүрэлдэхүүн: Ажлын ертөнцийг таньж мэдэх, ойлгох
Катологи ашиглах арга	Мэдээлэл цуглуулах арга

<p>Зорилго: Суралцагчид өөрийн нас, хөгжилд тохирсон сонирхлоо тодорхойлох, түүний дагуу ажил мэргэжлийг яаж судлах, яагаад судлах хэрэгтэй талаар мэдэх</p> <p>Хэрэглэгдэхүүн: Ажлын хуудас</p> <p>Сургалтын үйл ажиллагаа</p> <ol style="list-style-type: none"> 1. Суралцагчдаас дор бүрээ чимээгүй өөрийнхөө талаар эргэцүүлж бодохыг хүснэ. 2. Тэднийг өөрийн насны хөгжилд тохирсон сонирхлоо тодорхойлох мэдээллийг катологаас олохыг зөвлөн. 3. Суралцагчид мэдээллийг олж уншиж танилцана. 4. Суралцагчдад өөрийн нас, хөгжилд тохирсон сонирхлоо жагсааж бичнэ. 5. Мэдээллийг бусадтай хуваалцаж, ижил төстэй байдлаар нь ангилж ярилцана. 6. Ярилцсаны дараа түүнд тохирох ямар ажил мэргэжил байдаг талаар ярилцана. 	<p>Зорилго: Суралцагчдад өөрсдийн сайн мэддэг орчинд байдаг (тухайлбал сургуулийн орчин) ажил хөдөлмөрийн төрлүүдийг тодорхойлох, энэ ажил хөдөлмөрийг амжилттай эрхлэх эсвэл байгууллагыг амжилттай удирдаж ажиллуулахад ямар үүрэг хариуцлагууд байж болох талаар ойлголт өгөх</p> <p>Хэрэглэгдэхүүн: Хэвлэмэл хэлбэрээр бэлтгэсэн материалыг суралцагчдад өгөх</p> <p>Сургалтын үйл ажиллагаа</p> <ol style="list-style-type: none"> 1. Суралцагчдыг тус бүрт гурав гурван гишүүн бүхий багт хувааж, сургуулийн орчинд байдаг бүх төрлийн ажлыг тайлбарын хамт бичих, түүнчлэн сургуулийн гол гол хүмүүсийн албан тушаалын нэрийг жагсаан бичих даалгавар өгнө. 2. Багуудын бичсэн зүйлийг бусад суралцагчдад уншиж өгнө. 3. Хэрвээ суралцагчид сайн мэдэхгүй бол тэдэнд албан тушаалын нэр, юу хийдэг талаар тарааж өгсөн хэвлэмэл матеоиалаас уншихыг зөвлөнө. 4. Суралцагчид сургуулийн гол гол албан тушаалтнуудыг нэр, ажил үүрэгтэй холбоотой нэмж судалгаа хийж болно. 5. Ажлын хуудсан дээрээ албан тушаалын нэр, юу хийдэг талаар товч тайлбар бичнэ. Хүмүүсийн нэр бас ярилцлага хийх зорилгоор зай үлдээж болно. Ажлын хуудас дараах бүтэцтэй байж болно. Үүнд: Удирдлага менежмент: Захирал, Багш нар . номын сан Захиргааны ажилтан: Туслахууд, нарийн бичиг Санхүү, нягтлан бодогч, Нярав Гал тогоо, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, хамгаалалт, унаа тээвэр болон дэлгүүрийн ажилтан, албан хаагчид Бусад 6. Суралцагчид тодорхой нэг хүнийг сонгоод ярилцлага хийж болно. 7. Сургуулийн ажилтан, албан хаагчдаас хэсэг хүмүүс хичээлд оролцож өөрсдийн хийдэг ажлын талаар ярьж болно.
--	--

Бүрэлдэхүүн: Нөлөөлөх хүчин зүйл Үг дамжуулах арга	Бүрэлдэхүүн: Зорилго Амьдралын мөчлөгийн хуваарь
<p>Зорилго: Суралцагчдад ажил мэргэжилтэй холбоотой элдэв цуу яриа чухал мэдээллийг үгүйсгэх сөрөг үр дагавартай тул худал, үнэнийг нь эх сурвалж материалыг судалж тогтоох хэрэгтэй гэдгийг ойлгуулах.</p>	<p>Зорилго: Суралцагчдад өөрсдийн өнгөрсөн болон ирээдүйн ажил, амьдралын талаар урт хугацааны мөчлөгт хуваарь хэрхэн хийх талаар ойлголт өгөх</p> <p>Хэрэглэгдэхүүн: Суралцагч бүрт А4 хэмжээтэй хуудас цаас, ажлын хуудас</p> <p>Сургалтын үйл ажиллагаа</p>

<p>Хэрэглэгдэхүүн: Суралцагчдад богино хэмжээний ажил мэргэжлийн талаарх үгийг дамжуулах</p> <p>Сургалтын үйл ажиллагаа</p> <ol style="list-style-type: none"> 1. Суралцагчдыг бүлэгт хувааж (баг бүрт 8 хүүхэд байхаар), 1-8 хүртэл дугаарлана. 2. Багийн ахлагч нарыг самбарын өмнө дуудаж цуглуулаад багш тэдэнд ямар нэг үйл явдлын талаар (болсон явдал ч байж болно) ярина. 3. Ингээд багийн ахлагч нарыг ангийн буланд эсвэл хананд бие биенээсээ зайтай зогсооно. 4. Багийн ахлагч бүр өөрийнхөө багийн нэг гишүүнийг дуудаж сонссон үйл явдлаа чихэнд нь дамжуулах . Багийн ахлагч, гишүүн 2 буцаж багтаа ирээд сууна. Ингээд багийн гишүүн дараагийн гишүүндээ дамжуулах, дараагийнх нь дараангийнхдаа гэх мэт бүх гишүүд сонсоно. 5. Ингээд багийн хамгийн сүүлд сонссон гишүүн гарч ангийнхандаа юу сонссон талаараа ярина. 6. Ингээд ангийн суралцагчид аль баг энэ үйл явдлын талаар хамгийн үнэн зөв зүйл ярьсан бэ гэдэгт санал өгнө. 7. Багш ангийн суралцагчдын яриа, хэлэлцүүлгийг удирдах ба ингэхдээ мэдээллийн үнэн зөв байдал цуу яриагаар хэрхэн алдагддагийг танилцуулна. Ялангуяа ажил мэргэжил, сургалтыг талаарх цуу яриа хувь хүнд яаж нөлөөлж болох талаар суралцагчидтай ярилцана. <p>Холбогдох үйл ажиллагаа: Энэ даалгаврыг ажил мэргэжилтэй холбоотой мэдээллийн үнэн зөвийг тогтоох судалгаанд ашиглаж болно. Өөрөөр хэлбэл суралцагчид мэдээллийн үнэн зөв байдлын талаар судалгаа хийж болно.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Суралцагчдад хос хосоороо ажиллах хэрэгтэй гэдгийг хэлнэ. 2. А4 цаасны голоор дээрээс доошоо хүртэл шулуун шугам татах даалгавар өгнө. 3. Энэ шулуун шугамны голд нь Х тэмдэглэгээ хийж дор нь тухайн оноо 2021 (эсвэл 2022) гэж бичнэ. 4. Шулуун шугамны гол тэмдэглэсэн Х тэмдэглэгээг дайруулан хөндлөн шулуун шугам татна. Зүүн талын хөндлөн шугамын эхэнд төрсөн оноо харин баруун талын хөндлөн шугамны эцэст 2026 эсвэл 2027 он гэж бичнэ. Өөр он ч бичиж болно. 5. Ингээд зүүн талын хөндлөн шугамаа 8-10 хэрчимд (10-с олон ч байж болно) хуваана. Энэ хэрчим тус бүрт өөрийн өнгөрсөн амьдралд тохиолдсон 8-10 чухал үйл явдлыг энэ үйл явдал тохиолдсон оны хамт бичнэ. Жишээ нь 2020 онд болсон онцгой үйл явдлыг хөндлөн шугамаа хэрчмүүдэд хуваагаад эхний хэрчимд “Дэлхий даяар халдварт өвчин дэлгэрсэн ” дараа нь 2021 он гэж бичээд “Теле хичээл зохион байгуулагдсан ” гэж бичих жишээтэй. 6. Суралцагч бүрийг дээрх үйл ажиллагааны дагуу онцгой үйл явдлаа аль болох дэлгэрэнгүй бичих даалгавар өгнө. 7. Дараа баруун талын хөндлөн шугамаа мөн хэрчмүүдэд хуваагаад хэрчим бүрт юу хийх төлөвлөгөөтэй байгаагаа оны хамт бичнэ. Жишээ нь эхний хэрчимд 2020 он гэж бичээд доор нь “би биеэ даан суралцаж,ирээдүйнм ажил мэргэлжээ тодорхойлон ”, дараагийн хэрчимд 2024 он гэж бичээд доор нь “12-р ангиа төгсөнө” гэх мэт бичих жишээтэй. Үүнийг 2028 он хүртэл хэрчим тус бүртээ бичсэн байна. 8. Ингээд энэ мөчлөгт хуваарийг хийж дууссаны дараа суралцагч бүрийг хамтрагчдаа ирээдүйн төлөвлөгөөнийхөө талаар ярилцах даалгавар өгнө. 9. Багш суралцагчдаас мөчлөгт хуваарьт бичсэн зүйлүүдээс хамгийн сонирхолтойг нь сонгон ярилцах даалгавар өгнө.
---	---

Бүрэлдэхүүн: Сонголт хийх болон шийдвэр гаргах	Бүрэлдэхүүн: Үйл хэрэг болгох
<p>Өдрийн тэмдэглэл хөтлөх</p> <p>Зорилго: Суралцагчдад өдөр тутамд хийдэг үйл ажиллагааны зарим нь суралцагчдын өөрсдийн сонголт байдаг, энэ сонголт нь хүн бүрт өөр өөр байдаг талаар ойлголт өгөх.</p> <p>Хэрэглэгдэхүүн: 2 том тойрог зурсан ажлын хуудас</p> <p>Сургалтын хэрэглэгдэхүүн</p>	<p>Аккурамын арга</p> <p>Зорилго: Суралцагчид дунд ангийн суралцагчдаас ажил мэргэжилтэй холбоотой ярилцлага хийхэд бэлтгэх болон ярилцлага авах</p> <p>Хэрэглэгдэхүүн: Ярилцлагад оролцох 12 суралцагч болон ярилцлага хийх цаг, өрөө</p> <p>Сургалтын хэрэглэгдэхүүн</p>

<p>1. Суралцагчдад хоорондоо ярилцаж амралтын нэг өдөр юу хийдэг жагсаалтаа гаргах даалгавар өгнө. Жишээ нь унтах, идэх, ном унших, номын санд суух, гэрийн даалгавар хийх гэх мэт</p> <p>2. Суралцагчдад дээр дурдсан үйл ажиллагаа тус бүртээ ямар хугацаа зарцуулдагаа тооцох даалгавар өгнө. Нийт хугацаа 24 цаг болж байх ёстой болохыг сануулна.</p> <p>3. Суралцагчид үйл ажиллагаа болгонд зарцуулсан хугацаагаа процентоор илэрхийлэх даалгавар өгнө.</p> <p>4. Ингээд процентоо ашиглан нэг өдрийн үйл ажиллагаагаа дугуй диаграмаар илэрхийлэх даалгавар өгнө.</p> <p>5. Суралцагчдаар өмнө хийсэнтэй ижил даалгавар гүйцэтгүүлэх ба ингэхдээ ням гариг эсвэл ямар нэг баярын амралтын өдрөөр үйл ажиллагааг бичихийг сануулна.</p> <p>6. Суралцагчдад хийсэн дугуй диаграмаа бусдадаа үзүүлж тэдний хийсэн диаграмаас юу нь ялгаатай бас ижил байгааг тодорхойлох даалгавар өгнө. Холбогдох үйл ажиллагаа</p> <p>Суралцагчдад өөрсдийн гэр бүлийн нэг гишүүнийг сонгон нэг өдрийнх нь үйл ажиллагааг дээр дурдсаны дагуу судалж диаграм байгуулах даалгавар өгч болно. Ингээд тухайн суралцагчийн өөрийн үйл ажиллагааны диаграмаас юугаараа ялгаатай болохыг тодорхойлуулж болно.</p>	<p>1. Суралцагчдаар сугалаа сугалуулна. Я,А гэсэн 2 үгийг сугалуулах Энэ нь Я-ярилцах, А- ажиглах.</p> <p>2. Я-г сугалсан сурагчид дотор талдаа, А-г сугалсан сурагчид бусдын үзэл бодлоо илэрхийлж байгааг ажиглана. Ингээд багуудад ярилцлага хийх ерөнхий арга зүйг танилцуулна.</p> <p>2. Ярилцлага хийх арга зүйн талаар ярилцаж, ямар нээлттэй бас хаалттай асуулт асууж болох талаар зөвшилцөнө.</p> <p>3. Суралцагчид баг дотроо ажил мэргэжлийн сонголтын талаар сонирхолтой мэдээллийг хаанаас, рэхэн авч болох талаар ярилцах даалгавар өгнө.</p> <p>4. Ингээд баг бүр 4 асуулт сонгож бэлдэнэ. 4 асуултаа бусад багийн асуултуудтай нийлүүлж ангиараа ярилцаж байгаад хамгийн сонирхолтой 6 асуулт сонгоно.</p> <p>5. Суралцагчдад 6 асуулт, түүний хариултыг бичих зай бүхий ярилцагын хуудас бэлтгэх даалгавар өгнө.</p> <p>6. Хос болж ажиллаж буй хамтрагчид бие биенээсээ 3, 3 асуулт бичиж хариултыг нь бичнэ.</p> <p>7. Ярилцлагад оролцох суралцагчидтай хэрхэн холбогдох, хаана, хэзээ уулзах, ярилцлагын нээлтээ хийхэд хэн туслах гэх мэт үйл ажиллагааг төлөвлөх даалгавар өгнө.</p> <p>8. Суралцагчид хамтрагчаа солиод дахин нэг ярилцлага хийж үзэх ба ямар бэрхшээл байсан талаар ангийхандаа мэдээлнэ.</p> <p>9. Суралцагчдад ярилцлага хийх, ярилцлагын үр дүнгээ товч байдлаар тайлагнах даалгавар өгнө.</p> <p>Ярилцлага хийхтэй холбоотой үйл ажиллагаа: Суралцагчид дунд ангийн хэд хэдэн суралцагчдаас ярилцлага авна. Тэдний хариултад нийтлэг зүйл байгаа эсэхийг шинжилнэ.</p>
--	--

Бүрэлдэхүүн: Эргэн харж, дүгнэх
Дунд анги
<p>Зорилго: Суралцагчдад өөрийгөө ойлгоход дэмжлэг үзүүлэх үүднээс өмнөх ангиудад судалсан хичээлийнхээ талаар эргэн харж, дүгнэхэд туслах</p> <p>Хэрэглэгдэхүүн: Асуулт бичсэн хуудсууд</p> <p>Сургалтын үйл ажиллагаа</p> <p>1. Суралцагчдад дараах асуултуудын дагуу дунд ангийн сургалтынхаа талаар эргэн харж дүгнэх даалгавар өгнө. Асуултууд нь:</p> <ul style="list-style-type: none"> •• Сургуульд байсан сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн чинь хамгийн бахархмаар амжилттай байсан зүйл юу вэ? •• Ямар хичээлд хамгийн дуртай байсан бэ? •• Ямар хичээлд хамгийн сайн байсан бэ? •• Ямар хичээл хамгийн хэцүү байсан бэ? •• Сургуулиас гадуурх ямар үйл ажиллагаанд хамгийн дуртай байсан бэ? <p>Яагаад?</p> <p>2. Дээрх асуултын хариултыг хос хосоороо ярилцана.</p>

3. Хос хосоороо дараах асуултын талаар бодож эргэцүүлэх, ярилцах даалгавар өгнө. Үүнд:

- Хамгийн сайн сурдаг эсвэл дуртай байсан хичээлдээ яаж илүү сайн болж болох вэ?
- Хамгийн хэцүү байсан хичээлээ үргэлжлүүлэн сурах хэрэгтэй болбол яаж сайн сурч болох вэ?

Холбогдох үйл ажиллагаа:
 Дээрх асуултуудын хариултын талаар эцэг эхтэйгээ зөвлөлдөх даалгавар өгнө.
 Хөтөлбөрийн сонголтыг харгалзах:
 Тодорхой хичээл дээр сайн сурах эрмэлзэлтэй байгаа суралцагчдад багш тусалж болох талаар снэл тавьж болно.

9-р ангид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Дараах хүснэгтэд хичээл сонголтын 7 хоногийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөлөө.

Цаг	Эхний өдөр
1	<ul style="list-style-type: none"> • Сонголтын 7 хоногийн зорилго • 7 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, дүгнэх • 7 хоногт хэрэгжүүлэх үйл ажиллагаанд • Суурь түвшний үнэлгээ хийх
2	<ul style="list-style-type: none"> • Сонирхолын 7 чиглэлийг танилцуулах • Гарын авлагын сонирхол тодорхойлох хэсэг дээр ажиллах • Сонирхолын үр дүнг бүлгээр хэлэлцэх
3	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн 28 салбарыг танилцуулах • Энэ салбаруудаас сонирхолын чиглэлийн дагуу сонгох • Үр дүнгээ бүлгээр хэлэлцэх
4	<ul style="list-style-type: none"> • Ажил мэргэжлийн нэрийг танилцуулах • Тохирох ажил мэргэжлийг өмнөх сонголтууд дээрээ үндэслэн сонгох • Үр дүнгээ бүлгээр хэлэлцэх
5	<ul style="list-style-type: none"> • Бүлэг бүр гэрийн даалгаварт ашиглах 5 асуулт сонгох • Гэрийн даалгавар өгөх – сонгосон 5 асуултаа ашиглан насанд хүрсэн 2 хүнээс ярилцлага авах

Цаг	Хоёр дахь өдөр
1	<ul style="list-style-type: none"> • Суралцагчдын сурлагын амжилт, дуртай эсвэл дургүй хичээлийн талаар ганцаарчлан эсвэл бүлгээр талаар эргэцүүлэн, дүгнэлт хийх
2	<ul style="list-style-type: none"> • Чадварын хэсгийг танилцуулах • Өөрийнхөө чадваруудыг тодорхойлох • Бүлгээр
3	<ul style="list-style-type: none"> • Үнэт зүйлийн талаар танилцуулах • Өөрийнхөө үнэт зүйлийг тодорхойлох • Бүлгээр хэлэлцэх
4	<ul style="list-style-type: none"> • Хувь хүний онцлог хэсгийг танилцуулах • Өөрийнхөө хувь хүний онцлогийг тодорхойлох • Бүлгээр хэлэлцэх
5	<ul style="list-style-type: none"> • Ажиллах арга барил хэсгийг танилцуулах • Өөрийнхөө ажиллах арга барилаа тодорхойлох • Бүлгээр хэлэлцэх

Цаг	Гурав дахь өдөр
1-2	<ul style="list-style-type: none"> Гэрийн даалгаврын гүйцэтгэлээ бүлгээр хэлэлцэнэ. Тухайлбал, хамгийн сонирхолтой эсвэл хачирхалтай зүйл юу байсан гэх мэт Анги хамт олноороо гэрийн даалгаврын гүйцэтгэлээ ойлгомжтой, бас онцлог хэв шинжийг тусган хүснэгт эсвэл диаграм байдлаар боловсруулна.
3	<ul style="list-style-type: none"> 10 дугаар ангийн хичээл сонголтын талаар тайлбар хийх
4	<ul style="list-style-type: none"> Суралцагчдаар түр зуурын сонголт хийлгэх Сонголтын талаар бүлгээр хэлэлцэж, бие биедээ санал зөвлөгөө өгөх
5	<ul style="list-style-type: none"> Энэ хугацаанд хийж гүйцэтгэсэн бүх зүйлээ гэр бүлийнхэндээ танилцуулж 10 дугаар ангид хийх сонголтын талаар хэлэлцэх даалгавар өгөх

Цаг	Дөрөв дахь өдөр
1	<ul style="list-style-type: none"> Гэрийн даалгавар эргэцүүлж дүгнэж, төлөвлөгөөний хуудас бүрэн бичигдэж дууссан эсэхийг шалгах
2-3	<ul style="list-style-type: none"> Ажлын арга барил болон, хүйсийн онцлогийн талаар ажлын дэвтэр дээр ажиллах Сургууль төгссөний дараах сонголтууд, тэдгээрийн элсэлтийн шаардлагуудын талаар судалж, дүн шинжилгээ хийх (аль болох олон асуудал хамрах)
4	<ul style="list-style-type: none"> Багш, суралцагч, эцэг эхтэй 10 минутын ярилцлага хийх, Үлдсэн суралцагчид суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой үйл ажиллагаа зохион байгуулах

Цаг	Тав дахь өдөр
1-4	<ul style="list-style-type: none"> Багш, суралцагч, эцэг эхтэй 10 минутын ярилцлага хийх, Үлдсэн суралцагчид суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой үйл ажиллагаа зохион байгуулах
5	<ul style="list-style-type: none"> Суурь түвшний үнэлгээ дахин хийх, энэ долоо хоногт хийгдсэн үйл ажиллагаануудын давуу болон сул талыг тодорхойлох, хэрхэн сайжруулах талаар хэлэлцэх

Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 4.1.1 заасны дагуу ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр дамжуулан сургалтыг дэмжих, танин мэдэхүйг хөгжүүлэх, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдрах ухаанд сургах зорилгоор намын сангийн агуулга, хэлбэрийг баяжуулах, төрөл бүрийн соёл олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах үүргийн хүрээнд дээрх арга хэмжээнд АУБ б болон сургалтын үйл ажиллагааг чиглүүлж буй багш нарт дэмжлэг үзүүлэх шаардлага урган гарч байна.

Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа зохион байгуулагдсаны үр дүн: Сургуулийн номын санч өөрийн сургуулийн дунд ангийн сурагчдад багш, эцэг эх, сургуулийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүн нь дараах байдлаар харагдана. Үүнд:

- Танай сургуулийг тухайн хичээлийн жилд дунд ангийн сурагчид сонирхол, сонголтын тухай ойлголтой болсон байна.

- Номын санчийн дэмжлэгтэйгээр сонголт хийх арга зүйгээс суралцсан байна .
- 9-р ангийн сурагчдид хичээл сонголт хийхэд бэлтгэгдсэн байна .
- Дунд ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр ямар мэргэжил эзэмших талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Дунд ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр эзэмших мэргэжлийг сонгохын тулд ямар хичээлийг судлах, түүнийгээ хэрхэн сонгож болох талаар мэдлэг ойлголтыг өгсөн байна. .
- Дунд ангийн сурагчид өөрийгөө таньж, зорилготой болж бие даах чадварт ахиц гарсан байна.
- Дунд ангийн сурагчдын хичээлд оролцох оролцоо сургалтын чанарт ахиц гарсан байна.
- Дунд ангиас ахлах ангид дэвшин суралцахад бэлтгэгдсэн байна.

Модуль боловсруулахад болон хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, ном зүй:

Гарын авлага: АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /8-9-р ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

Цахим эх сурвалж:

- www.mergejil.mn
- [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- www.onisep.fr
- www.myworldofwork.co.uk
- www.careers.govt.nz
- <https://myfuture.edu.au>
- <https://www.onetonline.org>
-

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг

үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ